

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Ойт цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/78/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2024.02.23</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Баян ташаагийн эх аудит ХХК-ийн захирал Т.Хоролсүрэн Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/77

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан мэдээлэл хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Чиглэл батлах тухай" 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу багш, байгууллагын гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээгээр нэг дүгээр түвшинд үнэлэгдэн 27,543.2 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасны дагуу цахим дэлгүүрээс 899,000

5020290

төгрөгийн өртөг бүхий 30 ширхэг таблетийг Техно зон ХХК-иас худалдан авсаныг машин тоног төхөөрөмж компьютерийн дансанд орлого авсан.

Аудитын гол асуудал

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтийг 11,368.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,107,755.7 мянган төгрөгөөр шинэчлэн баталсан нь “Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалинг нэмсэнтэй. Мөн БШУ-ны сайдын 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/170, 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/494 тоот тушаалуудаар төсөвт хөтөлбөр арга хэмжээ нэмсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Баян-Ойт сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 99.4 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	217,592,558.26	185,806,319.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	127,407,818.10	69,575,145.43
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	127,407,818.10	69,575,145.43
3121	Төгрөг	127,407,818.10	69,575,145.43
31211	Төрийн сангийн харилцах	127,407,818.10	69,575,145.43
35	БАРАА МАТЕРИАЛ	90,184,740.16	116,231,174.16
351	Түүхий эд материал	6,218,926.40	8,549,865.40
35110	Тусгай зориулалттай материал	5,627,724.40	8,549,865.40
354	Хангамжийн материал	83,965,813.76	107,681,308.76
35410	Бичиг хэргийн материал	2,687,500.00	2,309,500.00
35420	Аж ахуйн материал	45,921,676.13	46,766,676.13
35450	Барилгын засварын материал	1,044,605.00	12,753,000.00
35460	Хүнсний материал	20,000.01	855,100.01
35470	Бусад хангамжийн материал	34,292,032.62	44,997,032.62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,031,605,170.16	2,057,043,910.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,031,605,170.16	2,057,043,910.94
392	Биет хөрөнгө	2,031,605,170.16	2,057,043,910.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,053,020,473.00	2,057,055,573.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-126,246,144.41	-167,481,863.09
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	170,443,960.19	170,372,738.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-98,124,165.83	-56,544,600.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,005,589.53	65,049,634.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-70,041,582.87	-24,954,611.14
39217	Ном	13,547,040.55	13,547,040.55
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,249,197,728.42	2,242,850,230.53
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,249,103,495.87	2,242,850,230.53
51	Засгийн газрын хувь оролцоо	2,249,103,495.87	2,242,850,230.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	52,225,483.90	52,225,483.90
51101	Өмч: - төрийн	52,225,483.90	52,225,483.90
512	Хуримтлагдсан үр дүн	2,112,741,337.97	2,068,359,761.63
51210	Өмнөх үеийн үр дүн	2,112,741,337.97	2,112,741,337.97
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-44,381,576.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	84,136,674.00	122,264,985.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,249,197,728.42	2,242,850,230.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,171,363,709.90	1,332,673,161.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,982,509.90	22,848,761.00
120	Нийтлэг татварын бус орлого	36,982,509.90	22,848,761.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	490,000.00	3,960,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,750,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	490,000.00	210,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/	00.00	15,966,620.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/	00.00	2,922,141.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,134,381,200.00	1,309,824,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	939,246,400.00	1,107,755,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	939,246,400.00	1,107,755,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	195,134,800.00	202,068,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	195,134,800.00	202,068,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,068,012,962.66	1,377,054,737.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,068,012,962.66	1,377,054,737.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	913,454,760.69	1,208,828,604.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	573,541,600.89	817,318,592.56
210101	Үндсэн цалин	387,463,702.07	563,471,984.69
210102	Нэмэгдэл	127,329,906.57	192,698,864.87
210104	Урамшуулал	34,052,392.25	61,147,743.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,343,108.28	101,984,440.71
210201	Тэтгэврийн даатгал	48,603,233.73	69,508,171.32
210202	Тэтгэмжийн даатгал	5,648,930.69	8,174,128.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,651,227.67	6,539,302.54
210204	Ажилгүйдлийн даатгал	1,388,421.79	1,612,991.19
210205	Эрүүл мэндийн даатгал	11,051,294.40	16,149,847.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,493,053.03	157,822,817.07
210301	Гэрэл, цахилгаан	10,916,160.03	9,032,339.07
210302	Түлш, халаалт	121,317,597.00	140,687,626.00
210303	Цэвэр, бохир ус	6,259,296.00	8,102,852.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,765,709.20	16,749,000.00

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	6,561,000.00	12,377,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,427,600.00	4,371,500.00
2105	Нормативт зардал	4,731,790.00	02.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,731,790.00	02.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,570,000.00	16,445,155.00
210604	Урсгал засвар	21,570,000.00	16,445,155.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,197,842.85	5,784,956.85
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,197,842.85	5,784,956.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,811,656.44	92,723,640.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,656,300.00	27,147,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,263,300.00	584,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,892,056.44	64,991,890.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	154,558,201.97	168,226,132.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	143,099,255.00	157,033,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	127,815,255.00	129,490,560.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,284,000.00	27,543,240.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,458,946.97	11,192,332.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,458,946.97	11,192,332.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	103,350,747.24	-44,381,576.34
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	103,350,747.24	-44,381,576.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,134,871,200.00	1,313,784,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	490,000.00	3,960,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	490,000.00	3,960,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	490,000.00	3,960,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,750,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	490,000.00	210,000.00
120007	Навигацийн орлого		
120008	Монгол банкны ашиг		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,134,381,200.00	1,309,824,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	939,246,400.00	1,107,755,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	939,246,400.00	1,107,755,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	195,134,800.00	202,068,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	195,134,800.00	202,068,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	999,788,381.90	1,335,281,372.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	999,788,381.90	1,335,281,372.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,269,094.93	1,166,220,139.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	572,416,836.62	817,088,665.82
210101	Үндсэн цалин	386,433,161.38	553,381,194.63
210102	Нэмэгдэл	127,327,278.93	202,809,728.19
210104	Урамшуулал	33,960,796.31	60,897,743.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,587,272.43	102,308,600.00
210201	Тэтгэврийн даатгал	48,192,880.47	69,570,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,932,310.57	8,184,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,749,419.63	6,547,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,414,212.91	1,636,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,298,448.85	16,369,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,493,053.03	157,822,817.07
210301	Гэрэл, цахилгаан	10,916,160.03	9,032,339.07

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	121,317,597.00	140,687,626.00
210303	Цэвэр, бохир ус	6,259,296.00	8,102,852.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
210604	Урсгал засвар	17,400,000.00	33,053,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,692,342.85	7,064,956.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,679,590.00	48,881,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,924,090.00	38,283,850.00
210902		11,755,500.00	10,597,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	154,519,286.97	169,061,232.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	143,060,340.00	157,868,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	127,776,340.00	130,325,660.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,284,000.00	27,543,240.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,458,946.97	11,192,332.93
213403		11,458,946.97	11,192,332.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	135,082,818.10	-21,496,972.67
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,675,000.00	36,335,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,675,000.00	36,335,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,675,000.00	36,335,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,675,000.00	36,335,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-7,675,000.00	-36,335,700.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	127,407,818.10	-57,832,672.67
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	127,407,818.10
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	127,407,818.10	69,575,145.43

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	72,299,096.87	208,661,254.77
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	72,299,096.87	208,661,254.77
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,771,797.23	-2,771,797.23
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,112,741,337.97	2,249,103,495.87
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,112,741,337.97	2,249,103,495.87
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	38,128,311.00	00.00	38,128,311.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-44,381,576.34	-44,381,576.34
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	122,264,985.00	2,068,359,761.63	2,242,850,230.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			24,052,794.60	97.1
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,235,163,600.00	1,165,588,372.67	24,052,794.60	97.1
УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,163,600.00	1,165,588,372.67	23,504,794.60	97.0

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,049,451,200.00	1,007,719,472.67	13,276,586.65	97.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	854,235,000.00	817,088,665.82	3,824,779.97	99.1
Үндсэн цалин	586,306,900.00	553,381,194.63	8,852,514.37	90.4
Нэмэгдэл	223,778,000.00	202,809,728.19	5,771,709.31	88.0
Урамшуулал	44,150,100.00	60,897,743.00	-5,172,417.00	142.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,778,900.00	102,308,600.00	851,247.78	98.9
Тэтгэврийн даатгал	72,609,500.00	69,570,100.00	223,091.82	99.6
Тэтгэмжийн даатгал	8,542,300.00	8,184,400.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	6,833,900.00	6,547,800.00	31,362.77	99.4
Ажилгүйдлийн даатгал	1,708,500.00	1,636,500.00	76,399.66	93.8
Эрүүл мэндийн даатгал	17,084,700.00	16,369,800.00	520,393.53	95.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,065,200.00	7,064,956.85	1,276,360.17	97.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,065,200.00	7,064,956.85	1,237,736.46	87.4
Бараа үйлчилгээний бусад зардал	81372100.00	81257250.00	-84,872.97	102.1
Бараа үйлчилгээний бусад зардал	70,774,300.00	70,659,550.00	79.68	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,597,800.00	10,597,700.00	123,417.00	99.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	185712400.00	157868900.00	7,618,800.00	78.2
Бусад урсгал шилжүүлэг	185,712,400.00	157,868,900.00	7,618,800.00	78.2
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	158,158,300.00	130,325,660.00	481,800.00	99.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,554,100.00	27,543,240.00	481,800.00	99.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,107,755,700.00	1,107,755,700.00	-	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,107,755,700.00	1,107,755,700.00	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	1,107,755,700.00	1,107,755,700.00	548,000.00	99.0
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			548,000.00	99.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	41.00	41.00	-	100.0

Удирдах ажилтан	01.00	01.00	548,000.00	42.2
Гүйцэтгэх ажилтан	26.00	26.00	24,052,794.60	97.1
Үйлчлэх ажилтан	14.00	14.00	24,052,794.60	97.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн зорилгыг боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд суралцагчдын мэдлэг чадвар, багшийн хөгжлийг дэмжих, хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллах, үйлчлүүлэгчдийг дээдэлсэн тогтолцоог бүрдүүлэн, хамт олны хөгжил дэвшлийг хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Тус байгууллага нь дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Суралцагсдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс шинээр мөрдөгдөж эхэлсэн.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос (-6347.4) мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	127,407.8	69,575.1	-57,832.7
Авлага	0	0	0
Бараа материал	90,184.7	116,231.2	26,046.5
Үндсэн хөрөнгө	2,031,605.1	2,057,043.9	25,438.8

БНА-2024/78/НА-СТА-ТШЗ

Нийт хөрөнгө	2,249,197.6	2,242,850.2	-6347.4
Өр төлбөр	94,2	0	-94,2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү/	84,136.6	122,264.9	38,128.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,249,197.6	2,242,850.2	-6347.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,249,197.6	2,242,850.2	-6347.4

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал,

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 69,575.1 мянган төгрөг болж 57,832.7 мянган төгрөгөөр буурсан нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” А/534 дүгээр, 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” А/554 дүгээр тушаалын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг 2023 оны 12 дугаар сарын 17-ний өдрөөс хойшлуулсанаас Төрөөс иргэдэд олгох тэтгэмж дэмжлэгийн зардал дутуу олгогдсонтой холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 116,231.2 мянган төгрөг болж 26,046.5 мянган төгрөгөөр өссөн 23,715.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 2,922.1 мянган төгрөгийн сурах бичиг үнэ төлбөргүй хүлээн авсан, 591.2 төгрөгийн нэг удаагийн маск, PCL оношлуур, халуун хэмжигчийн ашиглалтын хугацаа дууссаныг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэр сургуулийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/56 тоот тушаалаар актлаж данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,057,043.9 мянган төгрөг болж 25,438.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр авсан үндсэн хөрөнгө 36,335.7 мянган, үнэ төлбөргүй хүлээн авсан 15,966.6 мянган, хөрөнгийн дахин үнэлгээгээр тоног төхөөрөмж данс 38,128.3 мянган төгрөгөөр нэмэгдэж үндсэн хөрөнгийн элэгдэл 64,991.9 мянган төгрөгөөр байгуулсантай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 94,2 мянган төгрөгөөр буурч тайлант онд өр төлбөргүй ажилласан байна

Засгийн газрын хувь оролцоо дансны өөрчлөлт нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 996,387.3 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 201,931.2 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтийг 11,368.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,107,755.7 мянган төгрөгөөр шинэчлэн баталсан нь “Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалинг нэмсэнтэй. Мөн БШУ-ны сайдын 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/170, 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/494 тоот тушаалуудаар төсөвт хөтөлбөр арга хэмжээ нэмсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 9 арга хэмжээг санхүүжүүлэх зардлын эх үүсвэрийг улсын төсвөөс 1,107,755.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 202,068.7 мянган төгрөгийг тус тус бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,107,755.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 190,876.3 мянган, өмнөх оны төсвийн хэмнэлтээс 24,052.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож нийт 1,322,684.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,437,232.3 мянган төгрөг буюу 97.1 хувьтай, орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 11192.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
80112	Нийтлэг үйлчилгээ	202,068.7	190,876.3	11,192.3	94,4

80226	Байр ашиглалтын үйлчилгээ	2,828.5	2,828.5	0	100,0
80312	Сургалт семинар	1,559.1	1,500.0	59.1	96.2
81605	Эрүүл мэндийг дэмжих	4,309.5	4,309.5	-	100.0
81801	Үдийн цай хөтөлбөр	158,158.3	130,325.6	27,832.4	82,4
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	35,159.9	35,120.0	39.9	99,8
81823	Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	6,607.8	6,599.3	8.4	99,8
81834	Боловсролын стандарт сургалтын хөтөлбөр төлөвлөгөө биелүүлэх	825,326.7	793,599.1	31,763.7	96,1
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах	201,177.8	191,306.3	9,871.4	95,1

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах төлөвлөгөөний дагуу үдийн хоол хүнсний материал 124,675.2 мянган төгрөгийн нээлтэй тендер шалгаруулалт, эрүүл мэндийн үйлчилгээ авах 2,826.1 мянган төгрөг, мэдээлэл технолийн үйлчилгээ авах 2,826.1 мянган төгрөгийн шууд худалдан авалтын аргаар нийт 130,327.4 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасны дагуу цахим дэлгүүрээс 35,120.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян ташаагийн эх аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Хандсүрэн, аудитор Б.Уранбилэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Ч.Чимгээ, захирал Т.Хоролсүрэн нар, дараагийн шатны хяналтыг аудитын ахлах аудитор М.Алтантуяа, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян ташаагийн эх аудит ХХК-д 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн үр дүнгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 1,309,824.4 мянган төгрөгийн 1.0 хувиар буюу 13,098.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 9,168.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхгүй арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин, нийгмийн даатгалын зардлуудад 79,099.2 мянга, бусад урсгал шилжүүлэгийн зардалд 28,546.5 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна. Орон нутгийн санхүүжилтээс байр ашиглалтын зардал дээр гэрэл цахилгааны зардал, цэвэр бохир усны зардлаас 1,805.2 мянган төгрөгийг хэмнэж төвлөрүүлсэн байна

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус сургууль нь “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг мөрдөж мэдээллийг хугацаанд нь тогтмол хугацаанд нь байршуулж ирсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар ямар нэгэн зөрчил илэрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 3,986.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдснөөс хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна. Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	495.0	1	495.0	100
Албан шаардлага	1	3,171.6	1	3,171.6	100.0
Акт	1	320.0	1	320.0	100.0
Дүн	3	3,986.6	3	3,986.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц зүйл байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тус сургууль нь үйл ажиллагааныхаа чиглэлийн дауу байгууллагын хуулийн хүрээнд болон санхүүгийн зарчмын хувьд хууль, дүрэм, журмыг зөрчөөгүй 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг болон материаллаг бус алдаа, зөрчил илэрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгөх санал хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.